

БАТЛАВ  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА | ЛБЯМБАСҮРЭН

## ГУРВАН АЙМГИЙН ГЭРЭЛ СУУЛТЫН ТЭМДЭГТҮҮДИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2019.04.15

### 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү техникийн тодорхойлолтод орон нутгийн нисэх буудлуудад шинээр суурилуулах хөөрч, буух зурвасны хүлээх байрлалын зааварлах тэмдэгтүүд болон явгалах зам заасан мэдээлэх тэмдэгтүүдийн техникийн үзүүлэлтийг тусгасан болно.

### 2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Нийлүүлэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн мэдээлэх тэмдэгтүүдийг нийлүүлнэ.

- Тэмдэгтүүд нь Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2010 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/245 дугаар тушаалаар баталсан “Аэродромд тавигдах шаардлагууд”-ын 5.6-д заасан шаардлагуудыг бүрэн хангасан байна.
- Тэмдэгтүүд нь олон улсын иргэний нисэхийн байгууллагаас гаргасан зөвлөмжид нийцсэн гэрлийн систем байна.
- Тэмдэгт нь эсвэл гэрэл суултын системийн үйлдвэрлэгч YOUYANG, ADB, TRANSCON, OCEM зэрэг компаниудын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сертификаттай бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц бүрэлдэхүүн хэсгүүдийг ашигласан байж болно.
- Тэмдэгтүүдийг тусгаарлах трансформатор, холболтын худгийн хамт иж бүрдлээр нь нисэх буудлуудын аэродромын гэрэл суултын системд холбон хүчдэлд залгахад бэлэн болгосон байна.
- Нийлүүлэгдэх бүтээгдэхүүн болон түүний бүрдэл хэсгүүд нь зайлшгүй шинэ байх шаардлагатай.
- Техникийн бичиг баримт нь англи, монгол хэл дээр байна.

### 3. ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	Тавигдах шаардлага
3.1	Хөөрч буух зурвасны хүлээх байрлалын зааварлах тэмдэгт	 Энэ тэмдэгт нь Ховд болон Баянхонгор аймгийн нисэх буудлуудад тус бүр нэг ширхэг нийлүүлэгдэнэ.
		 Энэ тэмдэгт нь Өвөрхангай аймгийн нисэх буудалд нэг ширхэг нийлүүлэгдэнэ.
		“34-16”, “14-32” тоо, тэмдэгтүүд нь улаан дэвсгэр дээр цагаан бичиглэлттэй байна. “А” үсэг нь хар дэвсгэр дээр шар бичиглэлттэй байна.
		Тэмдэгтүүдийн өндөр нь 800мм, суурийн хамт бол 1100мм, бичиглэлийн өндөр нь 400мм байна.
		Үсэг, тоо ба тэмдгийн хоорондын зай нь 64мм байх ба өргөний хэмжээ нь: <ul style="list-style-type: none"><li>• “А” үсэг: 340мм</li></ul>

		<ul style="list-style-type: none"> <li>• “1”-ийн тоо: 96мм</li> <li>• “2”-ын тоо: 274мм</li> <li>• “3”-ын тоо: 274мм</li> <li>• “4”-ийн тоо: 298мм</li> <li>• “6”-ын тоо: 274мм</li> </ul>	
3.2	Явгалах зам заасан мэдээлэх тэмдэгт	← A	Энэ тэмдэгт нь Ховд болон Баянхонгор аймгийн нисэх буудлуудад тус бүр нэг ширхэг нийлүүлэгдэнэ.
		A →	Энэ тэмдэгт нь Ховд болон Баянхонгор аймгийн нисэх буудлуудад тус бүр нэг ширхэг нийлүүлэгдэнэ.
		Энэ тэмдэгтүүд нь шар дэвсгэр дээр хар бичиглэлттэй байна.	
		Тэмдэгтүүдийн өндөр нь 600мм, суурийн хамт бол 900мм, бичиглэлийн өндөр нь 300мм байна.	
		Үсэг ба тэмдгийн хоорондын зай нь 48мм байх ба “А” үсэгний өргөний хэмжээ нь 255мм байна.	
3.3	Тусгаарлагч трансформаторууд болон холболтын худгууд	<ul style="list-style-type: none"> <li>• Тэмдэгт тус бүр тусгаарлагч трансформатортай байна.</li> <li>• Тусгаарлагч трансформаторууд нь хангалттай гэрэлтүүлэхүйц чадалтай байна.</li> <li>• Трансформатор тус бүр нь холболтын худагтай байна.</li> <li>• Нэг хэлхээн дэх тусгаарлах трансформаторуудын өндөр талын ороомгууд нь цуваа холболттой байна.</li> <li>• Холболтын худгууд нь гэрэл суултын системийн үйлдвэрлэгчийн байх.</li> </ul>	
		<p>Гэрлийн тэжээлийн кабель ба трансформаторууд нь газар доор дараах байдлаар хийгдсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• бүрэн далдлагдсан байх</li> <li>• нүх, суваг эсвэл ижил хэмжээний тусгаарлагч хайрцагт хийгдсэн байна.</li> <li>•</li> </ul>	
3.4	Бусад техникийн шаардлагууд	<ul style="list-style-type: none"> <li>• Тэмдэгтүүд нь хөнгөн, хэврэг материалаар хийгдсэн байх ба 60м/сек хүртэл салхийг тэсвэрлэхээр байна.</li> <li>• Тэмдэгтүүд нь тэгш өнцөгт хэлбэртэй байна.</li> <li>• Бүх тэмдэгтүүдийг дотроос нь гэрэлтүүлсэн байна. Гэрэлтүүлэг нь нисэх багийг гялбуулахааргүй хийгдсэн байх ба гэрэлтэлтийн хэмжээ нь аэродромын алсын барааны харагдац 800м-ээс бага байх үед: <ul style="list-style-type: none"> <li>- Улаан: <math>\geq 30\text{cd}/\text{m}^2</math></li> <li>- Шар: <math>\geq 150\text{cd}/\text{m}^2</math></li> <li>- Цагаан: <math>\geq 300\text{cd}/\text{m}^2</math></li> </ul> </li> <li>• Мэдээлэл өгөх хэсгээс бусад их биеийн хэсгийг цагаан өнгөөр будсан байна.</li> <li>• Бичиглэлүүд дэх сум болон хасах тэмдэгний өргөн зэргийг тухайн бичиглэлийн үсэгнүүдийн өндөртэй харилцан уялдаатайгаар тодорхойлно.</li> <li>•</li> </ul>	

#### 4. НИЙЛҮҮЛЭХ ТОО ХЭМЖЭЭ

№	Тоног төхөөрөмжийн нэр	Хэмжих нэгж	Нийлүүлэх тоо	Техникийн үзүүлэлт
---	------------------------	-------------	---------------	--------------------

4.1	Хөөрөх буух зурвасны хүлээх байрлалын зааварлах тэмдэгт	Иж бүрдэл	3	2 болон 3-т заагдсан үзүүлэлтүүдийг бүрэн хангасан байна
4.2	Явгалах зам заасан мэдээлэх тэмдэгт	Иж бүрдэл	4	

## 5. ХҮЛЭЭН АВАХ

Нийлүүлэгч тал нь техникийн үзүүлэлтийг бүрэн хангасан тэмдэгтүүдийг нийлүүлнэ.

ИНЕГ-ын даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу техникийн үзүүлэлт болон иж бүрдлийг шалгаж, ажил хүлээн авах актыг үйлдсэнээр барааг хүлээн авсанд тооцно.

Баталгаат засварын хугацаа нь ажил хүлээн авах комисс гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 12 сар байна.

Хянасан:


АНБЗГ-ын дарга



/Ё.Эрдэнэбат/

Боловсруулсан:

Үнэлгээний хорооны дарга:



/Ж.Батбаяр/

Гишүүд:



/Х.Ганбаатар/



/А.Амгалан/



/Д.Атарсайхан/



/Г.Хишигдэлгэр/

